



Хууль сахиулахуй

МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ ХЭРЭГСЭЛ АШИГЛАЖ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

THE SITUATION AND TRENDS OF HUMAN TRAFFICKING VIA DIGITAL PLATFORMS IN MONGOLIA

Х.Баатарбилэг

Дотоод хэргийн их сургуулийн докторант

Kh. Baatarbileg

Doctoral student, University of Internal Affairs, Mongolia

*хариуцлагатай зохиогч: Baatarbileg.Kh@gmail.com

Хураангуй: Цахим шилжилтийн эрин үед гэмт хэргийн “ертөнц” ч техник, технологитой илүү салшгүй холбоотой болж, хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд интернэт платформ, нийгмийн сүлжээгээр өргөн тархаж байна. Тодруулбал, сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн динамик, бүтэц, үйлдлийн арга хэлбэрт гүнзгий нөлөө үзүүлж байна. Цахим орчин, цахим хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшилтэт тал нь гэмт этгээдүүдэд хохирогчийг элсүүлэх, албадлагаар ажиллуулах, мөлжих болон тэдгээрийн үүсгэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдаалах зэрэг гэмт хэргийн бүхий л үе шатанд ашиглах боломжийг олгож байна. Мөн олсон хууль бус орлогыг санхүүгийн системээр дамжуулан халхавчлах, далдлахад цахим технологийн тусгай аргуудыг ашиглаж буй нь мөрдөн шалгах, гэмт хэргийг нотлох, яллах ажиллагааг нарийн, төвөгтэй болгож байна.

Энэхүү өгүүлэлд цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг, мөн түүнтэй ижил төстэй гэмт явдлын чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон.

Abstract: In the era of digital transformation, the “world” of crime has become increasingly inseparable from technology, with human trafficking-related activities spreading widely through internet platforms and social networks. In recent years, the rapid development of information and communication technologies has profoundly influenced the dynamics, structure, and operational methods of human trafficking. The advancement of digital tools and communication technologies enables offenders to exploit victims at every stage of the crime—recruitment, coercion into labor or sexual exploitation, promotion, and commercialization of the products or services derived from exploitation. Moreover, offenders increasingly use sophisticated digital mechanisms to conceal and launder illicit proceeds through financial systems, thereby complicating investigation, evidence collection, and prosecution processes. This paper aims to analyze the current situation and trends of human trafficking crimes committed through the use of digital tools and electronic means, as well as similar criminal activities, in order to identify emerging patterns and challenges in this field.

Түлхүүр үгс: Хүн худалдаалах гэмт хэрэг, цахим орчин, цахим хэрэгсэл, гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг.

Keywords: Human trafficking, cyber environment, digital tools, crime, sexual exploitation.

Сүүлийн жилүүдэд дижитал технологи, цахим орчны хурдацтай хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэл, зохион байгуулалт, арга хэлбэрийг эрс өөрчилж байна. Кибер орон зай нь гэмт этгээдүүдэд хохирогчийг элсүүлэх, хуурч мэхлэх, албадлагаар хөдөлмөр болон бэлгийн мөлжлөгт өртүүлэх, хууль бус

ашиг олох зэрэг үйл ажиллагаагаа илүү нарийн төлөвлөгөөтэй, хяналт тавихад хүндрэлтэй орчинд хэрэгжүүлэх шинэ боломжийг олгожээ. Цахим платформ, нийгмийн сүлжээ, шуурхай зурвасын аппликэйшнүүд нь хохирогчийг энэ төрлийн гэмт хэрэгт татан оролцуулах, уруу татах, улмаар тэднийг хяналтдаа





байлгах гол хэрэгсэл болж хувирсан байна. Монгол Улсын хувьд цахим хэрэглээний түвшин хурдацтай өсөж, тэр дундаа өсвөр үе, залуусын нийгмийн сүлжээн дэх идэвхтэй байдлын түвшин өндөр байгаа нь кибер орчин дахь хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Цахим шилжилтийн прогресс нь зөвхөн эрсдэл төдийгүй мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд ч мөн шинэ боломжуудыг нээж өгч байна. Тухайлбал, мөрдөн шалгах, өгөгдөл задлан шинжлэх, геолокац, блокчэйн болон бусад цахим технологийн-сайн практикуудыг ашигласнаар гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг шуурхай илрүүлэх, нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжтой. Нөгөө талаас, олон нийтийн боловсрол, мэдээллийн түвшнийг дээшлүүлэхэд цахим платформууд чухал үүрэг гүйцэтгэж, хохирогчид, тэдний гэр бүл, нийгэмд сэрэмжлүүлэх, тусламжийн эх үүсвэр рүү чиглүүлэх мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжтой.

Гэсэн хэдий ч, цахим орчны онцлогоос шалтгаалсан хүндрэл тулгарсаар байна. Тухайлбал, мөрдөгчдийн техник, технологи, эрх зүйн чиглэлийн ур чадварын хомсдол, олон улсын хил дамнасан цахим мөрдөх ажиллагааны зохицуулалт, түүний тодорхойгүй байдал, өгөгдөл хамгааллын шалтгаантай хязгаарлалт зэрэг нь гэмт хэргийн илрүүлэлт, баримт цуглуулалт, нотлох ажиллагааг хүндрүүлж байна. Эдгээр саад бэрхшээлийг даван туулахын тулд төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг

бэхжүүлэх, олон талт сургалт, мэдээлэл солилцох механизм, техникийн чадавхыг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Өөрөө хэлбэл, техник, технологийн хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн цар хүрээг тэлэх эрсдэлтэй хэдий ч, зөв зорилгоор, зохистой, ёс зүйн хүрээнд ашиглагдвал мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг олон талын ашигтай үр нөлөөг бий болгох боломжтой. Иймд стратеги, бодлого, сургалт, олон салбарын хамтын ажиллагаанд төвлөрсөн иж бүрэн хандлагаар мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт хэрэгтэй тэмцэх, тэр дундаа энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бүрэн ашиглах нь чухал байна. Энэ хүрээнд техникийн чадамжийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх, мэдээллийн бааз солилцоог олон улсын түвшинд зохицуулах, мөн иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг практик алхмуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсад 2015-2024 онд хүн худалдаалах гэмт хэрэг болон түүнтэй мөлжлөгийн хэлбэрээрээ төсөөтэй нийт 1089 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэг 97, 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” 33, 12.5 зүйлд заасан “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэрэг 776, 16.8 дугаар зүйлд заасан “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах” гэмт хэрэг 161, 16.9 дүгээр зүйлд заасан хүүхэд ашиглаж садар, самууныг сурталчлах 44 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

№	Гэмт хэргийн төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
1	13.1 Хүн худалдаалах гэмт хэрэг	6	3	12	10	14	10	7	11	11	13



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠤᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ
ᠭᠡᠮᠡᠲᠡ ᠶᠡᠳᠠᠯ ᠰᠤᠳᠠᠯᠠᠭ

2	12.3 Бэлгийн мөлжлөг	-	-	2	7	6	3	3	2	3	7
3	12.5 Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	30	28	40	83	118	69	75	85	130	118
4	16.8 Хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах	1	-	-	8	16	8	16	40	40	32
5	16.9 Хүүхэд ашиглаж садар самууныг сурталчлах	-	-	-	-	-	2	6	8	6	-

Хүснэгт 1. Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хүн худалдаалах, түүнтэй ижил төстэй гэмт хэргийн тоо

Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлох нэг гол шинж нь хүнийг мөлжих буюу ашиг олох зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогноулах буюу хүлээн авах үйлдлийн аль нэг нь хийгдсэн байх ёстой. Гэсэн хэдий ч, хүн худалдаалах гэмт хэргийг заавал нэг

байршлаас нөгөөд шилжүүлэх, өөр орон нутгаас өөр орон нутаг руу, нэг улсаас нөгөө улс руу тээвэрлэж байж үйлдэгддэг гэж үзэхгүй бөгөөд нэг нутаг дэвсгэрт зорчих эрхийг хязгаарлаж болон хязгаарлахгүйгээр үйлдэгддэг онцлогтой.



График 1. Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн тоо


Он	Хүн худалдаалах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл/				
	Хэрэг	Холбогдогч	Хохирогч		
			Нийт	Хүүхэд	Гадаад улсад хохирсон
2019	12	20	41	13	6
2020	5	8	33	10	5
2021	5	6	21	10	-
2022	6	10	31	15	-
2023	11	22	23	12	11
2024	13	8	12	1	1

Хүснэгт №2. Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн холбогдогч, хохирогчийн тоо

АНУ-ын Элчин сайдын яамнаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай 2022 оны тайлан” (ЭСЯам, 2022) -д “Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Норвегийн Хант Улс, Шведийн Хант Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс болон Арабын Нэгдсэн Эмират улс, бэлгийн мөлжлөгийн зорилгоор Бельгийн Хаант Улс, Камбожийн Хаант Улс, Бүгд

Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Хонконг Улс, Япон Улс, Макао, Малайз, Филиппин, Бүгд Найрамдах Солонгос Улс, Шведийн Хант Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Америкийн Нэгдсэн Улс руу худалдаж байна. Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Турк Улс руу визгүй зорчдог, шууд нислэгтэй, цар тахлын улмаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс хилээ хааснаар хүмүүсийн аялал, хөдөлгөөний чиглэл өөрчлөгдөн шинэчлэгдсэнтэй холбогдуулан БНТУ яваандаа хүлээн авагч орон болох магадлал байна” гэжээ.

Зураг 1. Монгол Улсын иргэд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж буй зураглал (IRIM, 2021)





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

Мөн эцэг, эхийнх нь зөвшөөрөлтэйгээр байгуулсан гэрээний нэрийн дор ажиллуулж байсан Монгол Улсын уран нугараач өсвөр насныхан, залуухан эмэгтэйчүүдийг гол төлөв Турк Улсад, мөн Хонконг болон Сингапур зэрэг орнуудад хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэх тохиолдол бүртгэгдсэн байна.

Үүнээс гадна Монгол охид, эмэгтэйчүүдийг “Монгол бариа” нэрийн дор үйл ажиллагаа явуулдаг газруудад

болон хууль бус үйлчилгээний байгууллагуудад ажиллуулах замаар бие махбодын болон эдийн засгийн шахалт, дарамтад оруулж, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байгааг судалгаанууд тэмдэглэж байна. Ийнхүү зочид буудал, баар, караоке, шөнийн цэнгээний газар зэрэг үйлчилгээний салбарт бүрэн эрхийн зөрчилтэй хөдөлмөр ашиглах нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогддог.




График 2. Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тоо

Монгол Улсад үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг дараах 3 чиглэлд ангилж үзэж болохоор байна. Үүнд:

1. Монгол Улсаас гадаад улсын чиглэлд;
2. Гадаад улсаас Монгол Улсын чиглэлд;
3. Монгол Улс дотооддоо.

1. Монгол Улсаас гадаад улсын чиглэлд.

Монгол Улсаас гадагшаа улс хооронд үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн урсгал чиглэлийн хүрээ нь газар зүйн хувьд ойр Азийн улс орнуудад илүүтэй төвлөрч байгаа боловч дэлхийн маш олон оронд Монгол Улсын иргэд худалдаалагдаж хохирогч болсон тохиолдлууд бүртгэгдсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, хохирогчдыг эгүүлэн татах үйл ажиллагаа зохион байгуулж, хамтарч ажилласан орнуудыг харгалзан үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн төрөл хэлбэрээс хамааран зонхилж буй урсгал чиглэлд ялгаа ажиглагдаж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай үйлдэгддэг тул мөрдөн шалгах ажиллагаа явуулахад цаг хугацаа, хүн хүч ихээр шаардагддаг төдийгүй хохирогч нь нэр төр, хувь хүний нууцтай холбоотой эмзэг асуудлаасаа болоод тэр бүр цагдаагийн байгууллагад хандаггүй бусад төрлийн гэмт хэрэг шиг бүртгэгддэггүй мөрдөгчөөс илрүүлж бүртгүүлдэг онцлогтой юм.

Зураг 2. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд (IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022)



Албадан хөдөлмөр эрхлүүлэх чиглэлд БНХАУ, БНЭнэтхэг, БНКазакстан, Норвеги, Швед, Турк болон Арабын Нэгдсэн Эмират улсуудад (Департамент, 2021) дурдагдсан байгаа бөгөөд сүүлийн 10 жилд ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор

Монгол Улсаас гадагшаа чиглэсэн хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний урсгал эрчимтэй нэмэгдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Зураг 3. Хөдөлмөр мөлжлөгийн зорилгоор Монгол иргэдийг худалдаалж буй орнууд (IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022)



Гадаад улсад биеэ үнэлдэг биеэ үнэлэгчид Зүүн Өмнөд азийн орнууд буюу Тайланд, Сингапур, Макао, Лаос зэрэг улсад өндөр цалинтай биеэ үнэлж гадны гэмт бүлэглэлд элсэн Монгол Улсаас охид эмэгтэйчүүдийг өндөр цалинтай ажилд зуучлах нэрээр бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэж байна.

Тухайлбал Малайз Улсын нийслэл Куала Лумпур хотод Монгол Улсын биеэ үнэлэгчдээс гадна Тайланд, Сингапур, Хятад, Орос, Вьетнам, Энэтхэг зэрэг улсаас охид, эмэгтэйчүүдээр ихээр очиж 1 удаагийн 800\$, хоногийн 1000\$ үнэ ханштайгаар биеэ үнэлүүлдэг ба Монгол Улсаас очсон охидыг эмнэлгийн шинжилгээнд хамруулж, зочид буудлын өрөөнд профайл зургийг нь авч өөрсдийн



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙ
ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ

албан ёсны сайтууд, вичат, телеграмм хуудсанд байршуулж зардаг байна.

Мөн Цахим орчинд нийтлэгдсэн “Вьетнам улсад өндөр цалинтай ажилд зуучилна” гэх зарын дагуу хууртагдан Камбож улсад бэлгийн мөлжлөг, цахим залилангийн гэмт хэрэг үйлддэг гэмт бүлэглэл нь Монгол Улсаас очсон иргэдийг

өр авлагын дарамт, шахалтад оруулж, хүч хэрэглэн айлган сүрдүүлэн тусгай зэвсэглэсэн хамгаалалт дор бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр буюу Монгол Улс руу чиглэсэн “телеграм” цахим залилангийн гэмт хэрэг хүчээр үйлдүүлж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгож байна.

Он	Хохирогчийн тоо	Эргүүлэн авчирсан улс
2014	4	Филиппин улс - 1, БНХАУлс - 1
2015	1	БНТУлс - 1
2016	4	БНХАУлс – 2, Малайз Улс – 1, БНСУлс - 1
2017	7	БНХАУлс - 7
2018	23	БНХАУлс – 14, Мьянмар Улс - 3, Малайз Улс – 2, Камбож Улс - 4
2019	1	БНТУлс - 1
2020	15	Малайз Улс – 15
2021	-	-
2022	15	Мьянмар Улс - 15
2023	12	БНХАУлс – 1, БНАЛУлс – 11
2024	5	Тайландын Хант Улс – 3, БНХАУлс – 2
2025	6	Камбож Улс – 5, Тайландын Хант Улс - 1

Хүснэгт 3. Гадаад улсаас эх оронд нь эгүүлэн авчирсан хохирогчдын тоо (ЦЕГ, 2025)

Монгол Улс сүүлийн жилүүдэд гадаадын улс оронд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг эх оронд нь эргэн авчрах, хамгаалж сэргээн нөхөн сэргээх ажиллагаанд онцгой ач холбогдол өгч байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд Зүүн болон Зүүн өмнөд Азийн хэд хэдэн орноос хохирогчдыг зохих журмын дагуу илрүүлэн шилжүүлэн авчирч, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлсэн нь энэ чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлогын тодорхой үр дүнг илтгэж байна.

Мөн Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Таксимийн төв талбай орчим цэнгээний газарт хэсэг бүлэг Монгол эмэгтэйчүүд биеэ үнэлж байгаа нь тэнд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа талаар Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэлд дурдагджээ (ЭЦА, 2025).

2025 онд цагдаагийн байгууллагаас Гадаад харилцааны яамны Консулын газар,

Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Элчин сайдын яамтай хамтран Камбожийн Хаант Улсаас энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын 5 иргэнийг эх оронд нь аюулгүй буцаан авчирсан байна.

Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох хамгийн эрсдэл өндөр бүлэгт тооцогдсоор байгаа бөгөөд хил залгаа болон хүн ам ихээр суурьшсан хотуудад анх удаа биеэ үнэлэх ажил хийхээр ирсэн Монгол охид, эмэгтэйчүүдийг өөрсдийн эрхшээлдээ оруулах зорилгоор гадаад паспортыг нь хураан авч зорчих эрхийг нь хязгаарлан хилээр буцаан гаргахгүй, визний хугацааг санаатайгаар хэтрүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгож буй тохиолдлууд нийтлэг байна. Мөн гэмт этгээдүүд хохирогчдыг өөрсдийг нь Монгол Улсаас өөр бусад охидыг элсүүлж авчруулах шаардлага тавьж гэмт этгээд болгож байгаа нь гэмт этгээдүүд

баригдахгүй байх, Эрүүгийн хариуцлагаас мултрах гол арга нь болж байгааг онцлох нь зүйтэй.

Мөн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бэлгийн цөөнх буюу ЛГБТ хүмүүсийн асуудал харьцангуй бага анхаарал татдаг байна. Цагдаагийн ерөнхий газарт хүн худалдаалах гэмт хэргийн ЛГБТ хохирогч бүртгэгдээгүй боловч салбарын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэгт (Азийн сан, 2022) тэмдэглэгдсэнээр, уг бүлгийн хүмүүс хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлтэй гэж үзэж байна.

2. Гадаад улсаас Монгол Улсын чиглэлд.

Дараагийн нэг чухал анхаарах чиглэл нь гадаад улсын иргэдийг Монгол Улсад хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх асуудал юм. Одоогийн байдлаар Монгол Улсад гадаадын иргэдийн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Гэсэн хэдий ч олон судалгааны тайланд дурдсанаар, гадаадын иргэд Монгол Улсад ажиллах явцдаа хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл харьцангуй өндөр байгааг тэмдэглэжээ.

Тодруулбал, Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын иргэдийг авчирч ажиллуулж буй зарим ажил олгогчид санаатайгаар цалин хөлсийг нь хугацаанд нь олгохгүй байх, эсвэл бусад байдлаар хөдөлмөрийн нөхцөлийг зөрчих байдлыг гаргадаг бөгөөд үүний улмаас тухайн иргэн хууль ёсны оршин суух эрхээ алдсан мэт нөхцөл үүсэж, Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн байгууллагад хандах, улмаар албадан гаргуулах эрсдэлд ордог. Ийнхүү гадаадын иргэд хөдөлмөрийн хөлсөө бүрэн аваагүй, хууль

ёсны эрхээ хамгаалж чадаагүйгээс хөдөлмөр мөлжлөгт өртөх боломжтой байна.

Мөн хөдөлмөр мөлжлөгийн эрсдэл зарим салбарт харьцангуй өндөр байгааг судалгаагаар нотолжээ. Тухайлбал, Монгол Улсад гэрээгээр ажиллаж буй гадаад иргэд барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхай зэрэг салбарт хөдөлмөрлөж байх үед илүү өндөр эрсдэлд өртөх тохиолдол гардаг байна (Төрийн департамент, 2021).

Тухайлбал, 2020 оны 9 дүгээр сард Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байсан Мьянмар улсын гурван иргэн хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн гэж үзэн хуулийн байгууллагад хандсан тохиолдол бүртгэгдсэн байна. Тэднийг хамгаалах, шаардлагатай тусламж үзүүлэх үйл ажиллагааг олон улсын болон орон нутгийн байгууллагууд, тухайлбал ОУШХБ болон ХТЭТ төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулсан бөгөөд энэ нь гадаадын иргэдийн хөдөлмөрийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх механизмын нэг жишээ болсон юм. Гэвч тэдгээр иргэдийг холбогдох байгууллагуудаар дамжуулан нутаг буцааж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Энэ чиглэлээр урьд гүйцэтгэсэн судалгаанд гадаадын иргэн ажиллуулах ажлын байрны төлбөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдан нэмэгдэж буй, мөн аж ахуй нэгжийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалаад хөдөлмөрийн визээр бус, бизнес болон жуулчлалын визээр буюу өөр ангиллын визээр гадаадын иргэд хил нэвтэрч орж ирэх болсон нь гадаад иргэдийн эмзэг байдлыг далимдуулах, хохироох, мөлжих эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ УЯАГ



Зураг 4. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэд, хөдөлмөр эрхлэх визтэй иргэдийн ажиллаж буй салбар

Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ)-ын 2024 оны IV улирлын мэдээллээр Монгол Улсад нийт 123 орны 16,111 иргэн долоон төрлийн визний ангиллаар түр болон байнгын зөвшөөрөлтэйгөөр оршин сууж байна. Тэдгээрийн 34% (n=6,239) нь хөдөлмөр эрхлэгч ангиллаар оршин сууж байгаагийн бараг хоёр хүн тутмын нэг нь уул уурхай, олборлолт болон барилгын салбарт

Эх сурвалж: ГИХГ 2024 оны мэдээлэл ажиллаж байна (**Error! Reference source not found.**). Хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийг улс орноор нь ангилбал, БНХАУ, ОХУ, Вьетнам, БНСУ, Энэтхэг болон Австралийн иргэд зонхилон ажиллаж байна. Газарзүйн байрлалаар авч үзвэл, тэдний ихэнх нь Улаанбаатар хот болон Дорнод, Өмнөговь, Дорноговь аймгуудад төвлөрөн хөдөлмөр эрхэлж байгаа нь ажиглагддаг.

№	Улс	Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо	%	Хөдөлмөр эрхэлж буй нийтлэг ажлын байр
1	БНХАУ	3531	62.8	Барилга, зам гүүр
2	ОХУ	272	4.8	Сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын салбарт
3	Вьетнам	234	4.1	Авто засвар
4	БНСУ	220	3.9	Зоогийн газар, гоо сайхан, үйлчилгээний салбарт
5	Австрали	134	2.3	Уул уурхай, хүнд үйлдвэр
6	АНУ	111	1.9	Уул уурхай, хүнд үйлдвэр
7	Филиппин	105	1.8	Хүүхэд асрагч, гэрийн үйлчлэгч
8	Өмнөд Африк	103	1.8	Спорт
9	Англи	62	1.1	Боловсрол
10	Канад	57	1.0	Уул уурхай, хүнд үйлдвэр
11	Япон	47	0.8	Массажист, гэрийн үйлчлэгч
12	Казахстан	36	0.6	Массажист, гэрийн үйлчлэгч
13	Бусад	705	12	Массажист, гэрийн үйлчлэгч

Хүснэгт 4. Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэд, улс орноор, нийтлэг ажлын байраар

Эх сурвалж: Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн мэдээлэл, 1212.mn

Мөн гэмт этгээдүүд албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан ОХУ, БНХАУ зэрэг улс руу худалдаалдаг байж болзошгүй мэдээллүүд бүртгэгдсэн байна (Department, 2021).

Гадаадын улсын иргэд Монгол Улсад хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй тохиолдлууд бүртгэгдэж байгаа хэдий ч, тэдний эрх ашгийг хамгаалах, шаардлагатай тусламж үзүүлэх, хууль ёсны эрхийг хангах боломжийг бүрэн хангах хууль эрхзүйн орчин тодорхой бус хэвээр байна. Үүний улмаас гадаад иргэдийг хохироох, хөдөлмөрийн мөлжлөгийн эрсдэлд оруулах тохиолдлуудад бүрэн хяналт тавих боломж хязгаарлагддаг.

Иймд цаашид Гадаадын иргэн, харьяатын газар болон хөдөлмөрийн хяналт шалгалтын асуудал хариуцсан төрийн байгууллагууд гадаадын иргэдийг хөдөлмөрийн болон бусад төрлийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдний эрх ашиг, аюулгүй байдлыг хуулийн хүрээнд хамгаалах чиглэлд системтэй, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын дотоод нөхцөл байдал.

Монгол Улсад Хүн худалдаалах гэмт хэрэг нь ар гэрийн хараа хяналт сул насанд хүрээгүй охид, эмэгтэйчүүдийг эмзэг мэдээллээр эрхшээлдээ оруулан зорчих эрхийг нь хязгаарлан гудамж талбайд буюу

“Хөдөө аж ахуйн яам”-ны автобусны буудал”, “Саппоро худалдааны төв”, “Улаанбаатар зочид буудал”-ын урд зэрэг цэгүүдэд зогсоож үйлчлүүлэгч олзлон үйлдэгддэг байсан бол сүүлийн үед сэжигтэй этгээдүүд цахим орчныг ашиглан садар самууныг сурталчлах, хуурамч фейсбүүкийн хаалттай группүүдийг олноор нээж иргэдээс урьдчилгаа мөнгө авч садар самуун агууламжтай (порно) бичлэг хийж зарах, бүртгэлгүй дугаараар зар байрлуулан бусдын биеийг үнэлүүлэх зэрэг арга, хэлбэрээр үйлдэгдэн, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нь зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, гэмт хэргийн гаралт, насанд хүрээгүй хохирогчдын тоо жил бүр өсөн нэмэгдэж байна.


Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 12.6 дугаар зүйл “Биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэрэг нь (Фейсбүүк, телеграм, вайбер, вичат, MY.mn сайт...болон бусад зарын сайтууд)-д, (high-class) фейсбүүк, инстаграм, тик ток нийгмийн цахим сүлжээнд олны танил (10.000-30.000 мянган дагагчтай) биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийг зохион байгуулдаг “Мадам”, “Агент” этгээдүүд нь урлаг соёл, бизнесийн нөлөө бүхий хүмүүст, мөн гадаад улсын БНХАУ, ОХУ, БНСУ, Япон Улсын иргэдэд зуучилж дундаас нь өндөр ашиг олдог нөхцөл байдал сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтээр тогтоогдож байна.



МОНГОЛ УЛСЫН ХҮҮЛЬ



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ



Зураг 5. Хүн худалдаалах гэмт хэргийн сүүлийн 5 жилийн дотоод нөхцөл байдал

Монгол Улсад хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртсөн ихэнх тохиолдлууд Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Тодруулбал, 2019-2021 оны хооронд бүртгэгдсэн 65 хэрэгт 131 хохирогч тогтоогдсоноос 66%¹ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна (IRIM, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, 2022). Бусад дүүргүүдтэй харьцуулахад Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт энэ төрлийн гэмт хэрэг илүү их бүртгэгдсэн нь онцлогтой.

Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн хэрэг үйлдэгдсэн газруудын 57.1% нь Саппоро төвийн орчимд төвлөрсөн бол, Баянзүрх дүүрэгт гарсан хэрэгт холбогдох үйлдлүүдийн дийлэнх буюу 30.8% нь Хүнс, хөдөө аж ахуйн яамны ойролцоох автобусны буудлын орчимд үйлдэгдсэн байна. Эдгээр статистик нь Улаанбаатар хотын тодорхой бүсүүдэд хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Хүйсийн тэгш эрх төв (ХТЭТ) ТББ-аас 2022 онд хийсэн судалгааны үр дүнгээр (ТББ, 2022) хуулийн байгууллагад хандаж тусламж авсан 20 хохирогчийн кейс өмнөх статистиктай ижил хандлагыг харуулж байна. Судалгаагаар дотооддоо хохирогч болсон 12 эмэгтэй бүгд Улаанбаатар хотод худалдаалагдсан бөгөөд тэдгээр нь нэг дүүргээс нөгөө дүүрэгт зуучлагчийн хамт хөдөлж үйлчилгээ үзүүлэх, эсвэл нэг байршилд баригдан бэлгийн мөлжлөгт өртсөн тохиолдлуудыг бүртгэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Улаанбаатар хотод өндөр байгааг хоёр шалтгаанаар тайлбарлаж болно. Нэгд, хот болон суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн боломжууд хотод илүү төвлөрсөнтэй холбоотой. Хоёрт, уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны чадавх, хяналт Улаанбаатар хотод төвлөрсөн нь хохирогчид илүү их бүртгэгдэх, мэдээлэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хэргийн илрүүлэлт, илэрсэн хэргийн давтамжийг харгалзан үзвэл, орон нутгуудаас хилийн ойролцоох аймаг,

¹ 2019-2021 оны хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн 131 хохирогчийн 66% (n=87) нь Улаанбаатар хотод, 6 хэрэг Өмнөговь

аймагт, 38 нь хилийн чанадад бүртгэгдсэн байна.

сумдууд дараагийн эрсдэлтэй бүсэд тооцогдож байна. Тухайлбал, Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжлийн нөлөөгөөр дотоодын болон олон улсын хөдөлгөөн эрчимжиж, БНХАУ-Монголын хилийн ойролцоо хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн эрсдэл нэмэгдэж байна.

Тодруулбал, Өмнөговь аймагт нүүрс тээвэрлэж буй ачааны машины жолооч нарын паспортыг ажил олгогчид нь тээврийн хэрэгслийн барьцаа болгон хураан авч байгаа нь хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй нэг хүчин зүйл болж байна. Ийм нөхцөл нь эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан, хамгаалалтгүй гадаадын иргэдийг өндөр эрсдэлд оруулж байгааг харуулж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг тодорхойлох судалгаанд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн бөгөөд тэдгээрийн нийлмэл нөлөөллийг тооцоолсноор аймаг, орон нутгийн эрсдэлийн түвшинг үнэлэхийг зорив. Үр дүнд нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх өндөр магадлалтай бүс нутгийг тодорхойлохдоо гурваас дээш сөрөг нийгэм, эдийн засгийн үзүүлэлт давхцаж буй аймаг, сумдыг “эрсдэл өндөр бүс” хэмээн ангилсан.

Эдгээр сөрөг хүчин зүйлсэд дараах үзүүлэлтүүд хамаарна. Үүнд:

■ 3 болон түүнээс дээш үзүүлэлт давхцсан ■ 2 үзүүлэлт давхцсан ■ 1 үзүүлэлт



Зураг 1. ХХГХ үйлдэгдэх эрсдэл бүхий байршлууд, эмзэг хүчин зүйлээр

- Ядуурлын түвшин өндөр, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн эзлэх хувь их байх;

- Гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр байх;

- Нийт гэмт хэргийн гаралт өндөр байх;

- Дотоод шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж байх;

- Хөдөлмөр эрхлэлт доогуур түвшинд байх.

- Ерөнхий боловсролын сургалтын чанар, үр дүн, хяналт хангалтгүй бага байх зэрэг үзүүлэлтүүдийг багтаана.

Эдгээр хүчин зүйлс нь нийгмийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, хүний эрх, эрх чөлөөнд халдах нөхцөлийг бүрдүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн суурь шалтгаан, өдөөгч орчны нэгэн үзүүлэлт болж байна.

Эдгээр макро түвшний хүчин зүйлсээс гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнх Монгол хохирогчдыг хөдөлмөр эрхлэлтийн аюултай сонголт хийхэд хүргэж, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болгоход хүргэж, гэмт этгээдүүдийн гарт ороход нь нөлөөлж байгааг ижил төстэй олон судалгааны үр дүн нотлон харуулж байна (Төрийн департамент, Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2021).





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

Эрсдэлт хүчин зүйлсийн давхардлыг авч үзвэл Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотын араас БНХАУ-тай хил залгаа Өмнөговь, Дорноговь аймгууд хамгийн эрсдэл өндөр орон нутагт тооцогдож байна.

Эрх бүхий байгууллагын мэдээлснээр, дотоодод гэмт бүлэглэлийнхэн цахим орчныг ашиглан санхүүгийн тусламж, зээл олгохтой холбоотой зар байршуулж охид, эмэгтэйчүүдийг хуурч татан оролцуулдаг байна. Улмаар тэднийг дарамтлах, айлган сүрдүүлэх зэрэг аргаар хяналтдаа авч, хувийн мэдээлэл болон дүрс бичлэгийг нь ашиглан заналхийлэх замаар эрх чөлөөг нь хязгаарлан орон сууц, нийтийн байр зэрэг газарт тусгаарлаж, бэлгийн мөлжлөгт өртүүлэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа талаар Цагдаагийн байгууллага мэдээлжээ. Түүнчлэн ЛГБТ хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байдлаас нийгмийн зүгээс гадуурхах явдал өндөр байдаг нь мөн улмаар эдгээр бүлгийн иргэдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор хохироох эрсдэлийг бий болгож байна (ЭЦА, Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл, 2025).

Иргэдийн цахим хэрэглээ жилээс жилд нэмэгдэж үүнийг даган цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийн гаралт, хохирлын хэмжээ ихсэж, олон нийтэд ноцтой хор уршиг учруулсаар байна.

Манай улсын цахим худалдааны суваг, тэдгээрийн төрлүүдийг авч үзвэл, 43 хувь нь фейсбүүк, 35 хувь нь цахим хуудас буюу Amazon, Taobao, Alibaba, eBay, Aliexpress, Tmall, 6 хувь нь инстаграм, үлдсэн 16 хувь нь аль аль хэлбэрийг хослуулан ашиглаж байна.

Монгол улсад интернэт хэрэглэгч: 2020 онд 307.166 байсан бол 2021 онд 379.727 буюу 19.1 хувиар, 2022 онд 436.447 буюу 12.9 хувиар, 2023 онд 498.889 буюу 12.5 хувиар тус тус өссөн. 2024 онд 439.963 буюу 11.8 хувиар буурсан хэдий ч 2025 онд 464.960 буюу 5.3 хувиар өсөх төлөвтэй байна.

Гар утас хэрэглэгч: 2020 онд 4.363.919 байсан бол 2021 онд 4.687.304 буюу 6 хувиар, 2022 онд 4.835.520 буюу 3

хувиар, 2023 онд 4.841.935 болж 0.1 хувиар, 2024 онд 5.194.742 болж 6.7 хувиар тус тус өссөн бол 2025 онд 5.392.964 болж 3.6 хувиар өсөх төлөвтэй байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн цахим сүлжээний хэрэглээ эрчимтэй өсөхийн хэрээр зохион байгуулалттай бэлгийн мөлжлөг цахим орчинд дамжин далд хэлбэрээр үйлдэгдэх хандлага нэмэгдэж байна. Тухайлбал, Facebook зэрэг платформ дээр тусгай зориулалтын групп, хуудас олон тоогоор үүсч, биеэ үнэлэлт зохион байгуулахад ашиглагдах болсон нь гэмт этгээдүүдэд хохирогчдыг илүү хялбар аргаар олж тодорхой хэмжээгээр удирдах боломжийг бүрдүүлж байна.

Эдгээр хуудас, группт байршуулсан заруудыг ашиглан “санхүүгийн дэмжлэг авна” гэх мэт шалтгаанаар мэдээллээ оруулсан охид, эмэгтэйчүүдийг гэмт бүлэглэлүүд янз бүрийн нэр болон шалтаг ашиглан уулзалтад дуудан эрхшээлдээ оруулдаг байна. Дараа нь хувийн мэдээлэл, бусдад түгээх боломжтой контент ашиглан дарамт үзүүлэх замаар тэдний эрх чөлөө, сонголтыг хязгаарлаж, шахалт үзүүлэх техникүүдийг хэрэглэдэг. Энэ мэт ажиллагаагаар тэднийг өөрийн хяналтад байлгаж, гуравдагч этгээдэд албадан үйлчилгээ үзүүлэхэд ашиглах нь бүртгэгдсэн.

Үүнтэй зэрэгцэн зарим тохиолдолд гэмт этгээдүүд хохирогчийн хувийн эд зүйлсийг хууль бусаар авах, нэр хүндэд халдах, хувийн мэдээлэл болон дүрс бичлэгийг ашиглан дарамт шахалт үзүүлэх зэрэг үйлдлээр заналхийлж байдгийг эрх бүхий байгууллагууд анзааруулж байна. Ийм нөхцөл байдал нь хохирогчдыг цахим орчинд үйлдэгддэг бэлгийн мөлжлөгийн илүү эмзэг, хамгаалалтгүй байдалд оруулдаг гэж үзэж болно.

Дүгнэлт

Монгол Улсад цахим орчныг ашиглаж үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн цар хүрээ, хэлбэр, бүтэц, орон зайн шинж чанар сүүлийн жилүүдэд эрс өөрчлөгдөж, улам бүр зохион байгуулалттай, олон улсын шинжтэй болж байна. Судалгааны үр дүнгээр цахим хэрэгсэл, нийгмийн сүлжээний



платформууд нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх шинэ орон зай болон хувирч, хохирогчийг элсүүлэх, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөн гэмт үйлдлийг нуун дарагдуулах үндсэн хэрэгсэл болж байгааг тогтоов.

1. Техник, технологийн хөгжил нь хүн худалдаалах гэмт хэргийн динамикт гол нөлөө үзүүлж байна. Цахим шилжилт, интернет хэрэглээний өсөлт нь гэмт этгээдүүдэд хохирогчийг цахим хэлбэрээр элсүүлэх, хуурч мэхлэх, дарамтлах зэрэг үйлдлийг хялбарчилсан бөгөөд энэ нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд хүндрэл, бэрхшээлийг учруулж байна.

2. Сүүлийн 10 жилийн статистик мэдээний дүнгээр Монгол Улсад хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэг 1000 гаруй бүртгэгдсэн нь уг гэмт хэрэг тогтвортой өсөх хандлагатайг илтгэж байна. Түүнчлэн хохирогчдын дийлэнх нь эмэгтэй, өсвөр насны, нийгмийн эмзэг бүлгийн төлөөлөл байгаа нь нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхой харуулж байна.

3. Гадаад чиглэлийн урсгал давамгайлж байгаа боловч дотоодын цахим хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан үйлдэж буй гэмт хэргийн гаралт нэмэгдэж байна. Монгол Улсын иргэдийг гадаад орнуудад бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах тохиолдол ихэвчлэн Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудад бүртгэгдэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд цахим залилан, албадан хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн хосолсон хэлбэр ажиглагдаж байна.

4. Дотоод орчны түвшинд цахим орчныг ашигласан гэмт хэрэг, тухайлбал, цахим хуудас, хаалттай бүлгүүд, зарын сайт, нийгмийн сүлжээг ашиглан биеийг үнэлүүлэх, садар самууныг сурталчлах, айлган сүрдүүлж дарамтлах хэлбэр зонхилж байна. Энэ нь хот суурин газрын дүүргүүд, ялангуяа Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт өндөр төвлөрөлтэй байна.

5. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлэгч макро хүчин зүйлс

(ядуурал, ажилгүйдэл, гэр бүлийн хүчирхийлэл, шилжилт хөдөлгөөн, боловсролын түвшин, хөдөлмөрийн зах зээлийн сул дорой байдал) нь орон нутаг бүрт харилцан адилгүй нөлөө үзүүлж байна. Судалгаагаар гурваас дээш сөрөг үзүүлэлт давхцаж буй аймгуудыг “эрсдэл өндөр бүс” гэж тодорхойлсон бөгөөд Улаанбаатар, Өмнөговь, Дорноговь зэрэг бүсүүд хамгийн эрсдэлтэйд тооцогджээ.

6. Мөрдөн шалгах болон хохирогч хамгаалах тогтолцооны чадавх сул байна. Цахим мөрдөн шалгах арга зүй, нотлох баримт цуглуулах чадамж, төрийн болон төрийн бус байгууллагууд, цаашлаад олон улсын хамтын ажиллагааны уялдаа сул байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөөг бууруулж байна.

7. Цахим технологийг зөв, ёс зүйтэй, нэгдсэн бодлоготой ашиглавал гэмт хэргийн илрүүлэлт, хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын шинэ боломжуудыг нээж өгч байна.

Санал

1. Мөрдөн шалгах байгууллагын техникийн болон хүний нөөцийн чадавхыг сайжруулах. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, өгөгдлийн шинжилгээ, блокчэйн мөрдөлт, дижитал нотолгоо цуглуулах арга зүйг эзэмшүүлэх сургалт, хөтөлбөрийг тогтмолжуулах нь зүйтэй.

2. Нийгмийн эмзэг бүлэг, өсвөр үе, залуусын цахим боловсролыг нэмэгдүүлэх. Хүн худалдаалах гэмт хэргийн цахим эрсдэлийг танин мэдүүлэх, мэдээлэл хамгааллын ур чадварыг нэмэгдүүлэх, сургууль, их дээд сургуулийн хөтөлбөрт кибер аюулгүй байдлын суурь мэдлэгийг тусгах.

3. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээг тогтмолжуулах. Аймаг, нийслэлийн түвшинд ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл, шилжилт хөдөлгөөн, боловсролын түвшний индексүүдийг нэгтгэсэн “эрсдэлийн газрын зураг”-ийг жил бүр шинэчилж, урьдчилан сэргийлэх бодлогод тусгах.

4. Гадаад иргэдийн хөдөлмөрийн нөхцөл, зуучлалын хяналтыг сайжруулах. Хөдөлмөрийн виз, гэрээний хэрэгжилт,



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙ
ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ

зуучлалын байгууллагын хариуцлагын тогтолцоог чангатгах замаар хөдөлмөрийн мөлжлөгийн эрсдэлийг бууруулах.

5. Иргэний нийгмийн оролцоо, хохирогч хамгааллын тогтолцоог өргөжүүлэх. Төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, хохирогчийн сэтгэлзүйн болон хууль зүйн тусалцааны хүртээмжийг сайжруулах, мэдээллийн сүлжээг нэгтгэх.

6. Олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх. Хөрш болон бүс нутгийн орнуудтай цахим орчны гэмт хэрэгтэй тэмцэх мэдээлэл солилцоо, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа, хохирогч хамгааллын хэлэлцээрийг шинэчлэх, хамтарсан платформ бий болгох.

7. Технологийн боломжийг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах. Мөрдөн шалгах байгууллагын цахим өгөгдлийн дүн шинжилгээний системийг хөгжүүлэх, хиймэл оюун, машин сургалт ашиглан цахим орчны гэмт хэрэг илрүүлэх автоматжуулсан шийдэл боловсруулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1.Department, U. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан*. АНУ: U.S Department.

2.IRIM. (2021). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа*. Улаанбаатар: IRIM .

3.IRIM. (2022). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан*. Улаанбаатар: IRIM.

4.IRIM. (2022). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан*. Улаанбаатар: IRIM.

5.IRIM. (2022). *Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан*. Улаанбаатар: IRIM.

6.Азийн сан, А. f. (2022). *ХХГХ-ийн чиг хандлага, түүнтэй тэмцэхэд тулгарч*

буй асуудал судалгаа. Улаанбаатар: Азийн сан.

7.Департамент, А.-ы. Т. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан*. Улаанбаатар: АНУ-ын Төрийн департамент.

8.ТББ, Х. (2022). *Хүн худалдаалах түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх дүн шинжилгээ судалгааны тайлан*. Улаанбаатар: ХТЭТ ТББ.

9.Төрийн департамент, А.-ы. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан*. АНУ: Төрийн департамент, АНУ-ын.

10.Төрийн департамент, А.-ы. (2021). *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан*. АНУ: Төрийн департамент, АНУ-ын .

11.ЦЕГ. (2025). *Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны тоо мэдээ*. Улаанбаатар: ЦЕГ.

12.ЭСЯам, А.-ы. (2022). *Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан*. Улаанбаатар: АНУ-ын ЭСЯам.

13.ЭЦА. (2025). *Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалахтай тэмцэх тасгийн мэдээлэл*. Улаанбаатар: ЭЦА.

14.ЭЦА. (2025). *Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл*. Улаанбаатар: ЭЦА.